

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 13-ны өдөр

Дугаар

БА-051/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 2 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, 93 (ерэн гурван) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/12/26 огноо, 0001918 дугаар, БА32024/0941;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: TL-01/21

2.3. Захиалагч: Нийслэлийн Орон сууцны бодлогын газар оноосон нэр, 000244722 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5673224 регистрийн дугаар Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын ам, Наадамчдын зам 1200, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын "Б" барилга, 9 давхар, 906 тоот, 70110733 холбоо барих утас, hpa@ub.gov.mn цахим хаяг;

Хару констракшн ХХК оноосон нэр, 9011582035 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6032745 регистрийн дугаар, БУ11-776/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, 19 дүгээр хороолол, 70-р байр, 2 давхар 2 тоот, 77711100, 88087459 холбоо барих утас, ita@haruconstruction.mn цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Мөнх ариун булаг ХХК оноосон нэр, 9011306060 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5510414 регистрийн дугаар, БУ11-794/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо, Баруун ард аюуш ХД-4-115 тоот, 99116807 холбоо барих утас, bayarbaatar13@yahoo.com цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Поверполарис ХХК оноосон нэр, 9011134050 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5191009 регистрийн дугаар, БУ11-430/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

УЯЛАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, 2-р хороолол, БЗ-30-25 тоот, 96961900, холбоо барих утас;

Айникс-Инженеринг ХХК оноосон нэр, 9011426001 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5731291 регистрийн дугаар, БУ17-345/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 30 дугаар хороо, хамба1, 21 тоот дугаар, 99113045 холбоо барих утас;

Мэйси бриллиант стийл ХХК оноосон нэр, 9011599110 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6048021 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 9 дүгээр хороо, зүүн салаа 5,14 тоот, 80111586 холбоо барих утас; brilliantsteel11@gmail.com цахим хаяг;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:Ти Эл прожект ХХК оноосон нэр, 9011705126 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6250599 регистрийн дугаар, ЗТ18-130/23 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Ууд дүүрэг, 2 дугаар хороо, 19-р хороолол, 20-13 тоот, 99994336 холбоо барих утас, info@tlp.mn цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ, Хэрэглэгчдэд үйлчлэх төв-10 оноосон нэр, 9014001026 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2117118 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Жаргалант үйлчилгээний төв-өөрийн байр, Хэрэглэгчдэд үйлчлэх төв-10, 89070010 холбоо барих утас, www.osnaaug.ub.gov.mn цахим шуудангийн хаяг;


Бадрах хотхон сууц өмчлөгчдийн холбоо оноосон нэр, 24/30 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9943617 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, 19-р хороолол, 13-р байр, 99161218 холбоо барих утас;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

- ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:
- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:



- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, 93 (ерэн гурван) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, 93 (ерэн гурван) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

ЛТ ШАЛГАЛТЫ
ГАЗАР


ууламжийг ашигл
уулах комисс

Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, Нийслэлийн Орон сууцны бодлогын газар,
Хару констракшн ХХК-ийн захиалгатай 93 айлын
үйлчилгээтэй орон сууц

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Орон
сууцны бодлогын газрын Төслийн
зохицуулалтын хэлтсийн дарга

Хару констракшн ХХК-ийн захирал


(А. Мөнгөн)
(Ч. Чулуунгэрэл)
(Р. Баасанбадам)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын
биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар: 2015-02685-19
Огноо: ... он ... сар ... өдөр
Бүртгэсэн: *D. M...*
УЛААНБААТАР ХОТ ТТМ 1584


1
илтанд

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 2 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ
БОДЛОГЫН ГАЗАР, ХАРУ КОНСТРАКШН ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ
16 ДАВХАР, 1 БЛОК, 8 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ
93 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Хару констракшн ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар, 8 автомашины дулаан зогсоол бүхий үйлчилгээтэй 93 айлын орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хурал 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 15 цагт тус барилгын нэг давхарын үйлчилгээний танхимд 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж 17:30 цагт дуусав.



Хуралд:

1. Комиссын дарга: Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнгөн
2. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Төслийн зохицуулалтын хэлтсийн дарга Ч.Чулуунгэрэл
Р.Баасанбадам
3. Захиалагч Хару констракшн ХХК-ийн захирал
4. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Шинэжаргал
5. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч З.Очирпүрэв
6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техникийн хяналтын инженер Б.Цэрэннадмид
7. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга Д.Сүхбат
8. Технологи удирдлага төлөвлөлтийн газрын Дэд бүтэц, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Н.Болор-Эрдэнэ
9. Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх албаны менежер Д.Болормаа
10. Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа М.Батсайхан
11. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батням
12. Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын ахлах архивч Э.Шижиртуяа
13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах

байгууллагын хүртээмжийн үнэлгээний ажилтан

Б.Ганбаатар

14. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
ОНӨААТҮГ-ын Дулаан хангамжийн инженер

Х.Очирбат

15. Зураг төсөл зохиогч Ти Эл Прожект ХХК-ийн
архитектор

О.Наранбаатар

16. Гүйцэтгэгч байгууллага Мөнх ариун булаг ХХК-ийн
ХАБЭА-н албаны дарга

Д.Даваажав

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 16
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 2 дугаар хороонд баригдсан Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Харү констракшн ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар, 8 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 93 айлын орон сууцны барилгын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч

Б.Шинэжаргал:

- Барилгад ашигласан материалын тохирлын гэрчилгээ, улаан журнал, ил далд ажлын /акт, бетоны бат бэхийн шинжилгээний бичиг/, лифтний магадлалын акт болон биелэлт үзүүлэх
- Заслын ажил дутуу 2 айлын заслыг дуусгаж, фото зургаар ирүүлэх
- Барилгын шилэн фасад силиконы ажлыг дуусгаж, дээвэр дээр байгаа люлкийг буулгах
- БТХ-ын 14.3, 14.6 заалтын дагуу зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааг гүйцэтгэгч, захиалагч байгууллага гаргаж ирүүлэх
- Зураг төсөл зохиогч зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчлэн баталгаажуулж ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Узелийн цэвэрлэгээ хийх, шугам тоноглол хаягжуулах, шугам дулаалах, ус зайлуулах трап хийх
- Айлуудын цэвэр усны босоо шугамын засвар үйлчилгээг хийх ревиз гаргаж таг хийх
- Цэвэр усны тоолуурт хаягжуулалт хийх

Барилга

- Алчуур хатаагчны төгсгөлд хий авагч мөн халаалтын коллекторт автомат хий авагч хийх
- Техникийн давхарын ашиглалтын айл өрхөөр ашиглахгүй баталгаа гаргах
- Дээвэр дээрх шахтны заслын ажлыг дуусгах
- Үнэр гаргагч малгайвчнаас дээш өндөр гаргаж дулаалсан "Т" тройник таг хийх
- НС-ийн шахтны малгайвчийг тороор битүүлэх
- Айлуудын халаах хэрэгсэлд термостат угсрах
- Ус, дулаан, агаар сэлгэлтийн шугам угсарсан ил, далд ажлын акт гүйцэд баталгаажуулан шалгуулах.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техникийн хяналтын инженер

Б.Цэрэннадмид:

- Ерөнхий оролтын самбарт хаяг бичиглэл схем, плакат хадах
 - Газардуулгын хүрээ, аянга хүлээн авах торыг зэврэлтээс хамгаалсан түрхлэг хийх.
 - ЦДКШ-уудад хаяг бирк хийх
 - Техникийн давхарт дутуу байгаа ажлыг гүйцээж фото зургаар шалгуулах
 - Гадна цахилгааны 0,4 кВ-н кабель шугамын ажлын зургийг холбогдох байгууллагатай зөвшилцөж баталгаажуулах
 - Дээврийн хэсэгт аянгын торонд холбогдоогүй төмөр хийцүүдийг бүрэн холбох
 - Үндсэн тэжээлийн холболтын протокол шалгуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга **Д.Сүхбат:**

- Халаах хэрэгсэлд термостат винтель тавих
- Дулааны узельд дутуу хийсэн тоног төхөөрөмж суурилуулах

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг хангуулж ашиглалтад хүлээн авах саналтай.

Технологи удирдлага төлөвлөлтийн газрын Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ:**

- Давхрын самбарууд болон сүлжээний утаснуудыг хаягжуулах
 - Холбооны өрөөний засварыг дуусгаж шал хийх
 - Домофон, зарлан, интернет сүлжээний ил далд ажлын актуудыг бүрдүүлэх
 - Айлуудын домофон суурилуулан хэвийн ажиллагаанд оруулах
 - 16 давхрын айлын галын дохиолол хийх /мөн зоорийн давхарт/
 - Камерийн сүлжээний утасыг Cat-5 татсан тул авторын дүгнэлтэд тусгах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газарын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчид үйлчлэх албаны менежер **Д.Болормаа:**

- Ундны усыг нийслэлийн эрүүл мэндийн газарт шинжилгээ өгч дүгнэлт гаргуулах

ХЯНАЛТ

га байгуу
оруу

- Бохир усны шугамын трасс өөрчлөгдсөн өөрчлөлтийн зураг батлуулах
 - Бохир усны гаргалгаа худгуудын түвшинг замтай тааруулж стандарт болгох
 - Цэвэр усны худагт галын гидрант суурилуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа **М.Батсайхан:**

- Зоорийн давхарт галын дохиолол мэдээлэгч хийх
- 88,89,103, дугаарлаагүй зогсоол зэрэг 4-н зогсоол ашиглах боломжгүй. Норм дүрэмд нийцүүлэх
- Техникийн давхарыг норм дүрмийн дагуу ашиглах баталгаа өгөх
- Өөрчлөлтийн зураг төсөл хянуулах
- Шатны хонгил тусгаарлах галд тэсвэртэй хаалгыг зураг төслийн дагуу хийх
- Барилгын гадна хананы дулаалга материалын гал тэсвэршилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга **Д.Батням:**

- Техникийн давхар өөрчлөгдсөн. Гүйцэтгэлийн зураг бодит гараагүй. Зориулалт өөрчлөгдсөн.
- Зургийн дагуу авто зогсоол төлөвлөсөн ч зураг нь норм ба дүрэм зөрчсөн. Зогсоол норм ба дүрэмд нийцэхгүй.
- Узель зөөгдсөн , холигч насосны узель өөрчлөгдсөн. Гүйцэтгэлийн зураг гараагүй.
- Узельд ус зайлуулах трап хийгдээгүй. Хаягжуулалт хийгдээгүй
- Тохирлын гэрчилгээ байхгүй.
- Цонх, гадна фасадны лаборатори хийлгэх
- Нормчлолын сангийн төвлөрүүлэлт хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Ганбаатар:**

- Нийтийн автозогсоолд ХБХ-н машинд зориулсан зогсоолын өргөн 3м95 машин зогсох зай 2м45 тэгэнцэртэй бууж суух зай 1м50 эрээн шугам татаж тусгаарлаж өгнө. Зогсоолын урд 1м 80 шон 30х45см багагүй самбар хийх.
 - Цахилгаан шатны хаалганы үйлдэл болон давхар зарлах спикер ажилд оруулах
 - 4ш үйлчилгээний заалны ариун цэврийн өрөөний суултуур угаалтуурт Бнбд 31-23-22 стандартын шаардлага хангасан туслах тоноглолын суурилуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын Ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх, баталгаажуулах.

ШАЛГА
АЗАР
тамжийг
тах коми

- Лифтэнд магадлал хийсэн тухай албан шаардлага, техникийн магадлалын актыг хувийн хэрэгт хавсаргах.
 - Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товьёг үйлдэх.
 - Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх.
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Ашиглалт хариуцах байгууллага: Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Дулаан хангамжийн инженер **Х.Очирбат:**

- В2 блокын барилгын узелийн өрөөнд хаягжуулалт хийх
- Шугамын дулаалга хийх
- Цэвэрлэгээ хийх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Зураг төсөл зохиогч: Ти Эл Прожект ХХК-ийн архитектор **О.Наранбаатар:**

- 2-8-р давхарын айлуудад дотор заслын ажил хийж гүйцэтгэх
 - Ариун цэврийн өрөөнүүдийн тоноглолуудыг сайтар шалгаж дутуу угсарсан хэсгүүдийг гүйцээх
 - Бүх давхрын шалны паркетийг шалгах. 4,5-р давхрын айлуудад шал хөөсөн хийг гишгэгдсэн байгааг засах
 - Зоориос бүх давхарт цэвэрлэгээ хийх
 - 1-р давхарт ариун цэврийн өрөөнд ХБИ-ний тоноглол суурилуулах
- Бусад комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахад татгалзах зүйлгүй.

Гүйцэтгэгч: Мөнх ариун булаг ХХК-ийн ХАБЭА албаны дарга **Д.Даваажав:**

- Заасан үүрэг даалгаврыг биелүүлж В2 блокын барилгыг хүлээн авахад татгалзах зүйлгүй.

Захиалагч Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Төслийн зохицуулалтын хэлтсийн дарга **Ч.Чулуунгэрэл:**

- Баримт бичгийн бүрдлийг дугаарлаж стандартын дагуу бичиг баримтын бүрдлийг хангах.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгаа гаргаж албан бичгээр ирүүлэх
- Техникийн давхарыг зөвшөөрөгдсөн зориулалтаар ашиглах баталгааг албан бичгээр ирүүлэх
- БНБД 11-04-16 дагуу зураг төсөл зохиогч зураг төслөөс өөрчилсөн ажлыг тусгаж дүгнэлт шинэчилж ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

